

# ХАРААТ БУС АУДИТОРЫН ТАЙЛАН

“Монгол Ардын Нам” ТББ-ын 2023 оны жилийн эцсийн  
нэгтгэсэн санхүүгийн тайланд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

УЛААНБААТАР ХОТ, 2024 ОН

“ИНТЕР АУДИТ” ХХК



# АГУУЛГА

## I. ХАРААТБУС АУДИТОРЫН ТАЙЛАН

## II. 2023 ОНЫ АУДИТ ХИЙСЭН НЭГТГЭСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

АУДИТ ХИЙСЭН НЭГТГЭСЭН САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

АУДИТ ХИЙСЭН НЭГТГЭСЭН ОРЛОГЫН ДЭЛГЭРЭНГҮЙ ТАЙЛАН

АУДИТ ХИЙСЭН НЭГТГЭСЭН ЦЭВЭР ХӨРӨНГИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН

АУДИТ ХИЙСЭН НЭГТГЭСЭН МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН

## III. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

## “МОНГОЛ АРДЫН НАМ” ТББ-ЫН МЭДЭЭЛЭЛ

БАЙГУУЛЛАГЫН НЭР:	Монгол Ардын Нам ТББ
РЕГИСТРИЙН ДУГААР:	8488908
БАЙГУУЛЛАГЫН УДИРДЛАГА:	Л.Оюун-Эрдэнэ
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЧИГЛЭЛ:	Улс төрийн намын үйл ажиллагаа
БАЙГУУЛЛАГЫН ХАЯГ:	Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8 дугаар хороо, 14200, Б.Алтангэрэлийн гудамж – 3, Тусгаар тогтнолын ордон
УТАС:	11-323235

## АУДИТЫН КОМПАНИЙН МЭДЭЭЛЭЛ



АУДИТОР, МЭРГЭШСЭН НЯГТЛАН БОДОГЧИД

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ: Ч.МӨНХБАЯР

Аудитын компанийн хаяг:

Монгол улс, Улаанбаатар хот,  
Чингэлтэй дүүрэг, 5-р хороо, 6-р  
хороолол, Самбуугийн гудамж, Эм  
Эн тауэр, 802 тоот

Холбогдох:

Утас: 99004839  
Веб хуудас: [www.interaudit.mn](http://www.interaudit.mn)  
Фэйсбүүк хуудас: Интер Аудит ХХК / Inter Audit LLC  
Мэйл хаяг: [info@interaudit.mn](mailto:info@interaudit.mn)

ИНТЕР АУДИТ ХХК

№ 01 огноо 2024.03.12

# ХАРААТ БУС АУДИТОРЫН ТАЙЛАН

# 1

“Монгол Ардын Нам” ТББ-ын 2023 оны жилийн эцсийн нэгтгэсэн санхүүгийн  
тайланд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

# ХАРААТ БУС АУДИТОРЫН ТАЙЛАН

## “МОНГОЛ АРДЫН НАМ” ТББ-ЫН УДИРДАХ ЗӨВЛӨЛД

### ӨӨРЧЛӨЛТГҮЙ ДҮГНЭЛТ

Бид 2023 оны 12 дугаар сарын 31-ээр тасалбар болгосон нэгтгэсэн санхүүгийн байдлын тайлан, уг өдрөөр дуусгавар болсон нэгтгэсэн орлогын дэлгэрэнгүй тайлан, нэгтгэсэн цэвэр хөрөнгийн өөрчлөлтийн тайлан, нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан болон ач холбогдол өндөртэй нягтлан бодох бүртгэлийн бодлогын хураангуйг багтаасан санхүүгийн тайлангийн тэмдэглэлээс бүрдсэн “Монгол Ардын Нам” ТББ (цаашид “Байгууллага” гэх)-ын санхүүгийн тайланд аудит хийлээ. Бидний үзэж буйгаар “Монгол Ардын Нам” ТББ-ын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал ба уг өдрөөр дуусгавар болсон жилийн орлогын дэлгэрэнгүй тайлан ба мөнгөн гүйлгээ нь бүх материаллаг зүйлсийн хувьд Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандартын Нягтлан Бодох Бүртгэлийн Стандартуудын дагуу үнэн зөв, бодитой илэрхийлэгдсэн байна.

### ДҮГНЭЛТИЙН ҮНДЭСЛЭЛ

Бид энэхүү аудитын ажлыг Аудитын Олон Улсын Стандартын дагуу гүйцэтгэсэн. Уг стандартын дагуу хүлээсэн үүрэг хариуцлагаа энэ тайлангийн Санхүүгийн тайлангийн талаарх аудиторын үүрэг хариуцлага хэсэгт харуулав. Бид Нягтлан Бодогчдын Ёс Зүйн Олон Улсын Стандартын Зөвлөлийн Мэргэжлийн Нягтлан Бодогчдын Ёс Зүйн Дүрэм болон Монгол Улсын Мэргэшсэн Нягтлан Бодогчдын Ёс Зүйн Дүрмийн санхүүгийн тайлангийн аудиттай холбоотой зохих шаардлагуудын дагуу тус байгууллагаас хараат бус бөгөөд эдгээр ёс зүйн шаардлагуудад нийцүүлэн бусад ёс зүйн үүрэг хариуцлагаа бүрэн биелүүлсэн болно. Олж авсан аудитын баримт нотолгоо нь бидний гаргасан дүгнэлтийн үндэслэл болоход хангалттай бөгөөд зохистой гэж итгэж байна.

### АУДИТЫН ГОЛ АСУУДАЛ

Бидний мэргэжлийн үнэлэмжээр аудитын гол асуудал гэж тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн их нөлөөтэй асуудал юм. Санхүүгийн тайланд хийсэн аудитынхаа хүрээнд эдгээр асуудлуудыг нэгтгэсэн байдлаар авч үзсэн ба дүгнэлт гаргахдаа эдгээр асуудлуудад тус бүрчлэн дүгнэлт гаргаагүй болно.

Тайлант онд МАН нь өөрийн 31,377,169.2 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө, 75,742.5 мянган төгрөгийн биет бус хөрөнгөдөө элэгдэл, хорогдол тооцож бүртгээгүй байна. Энэ нь НББОУС 16 Үндсэн хөрөнгө, НББОУС 38 Биет бус хөрөнгө болон Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн холбогдох заалтууд зөрчигдөх, тайлан үнэн зөв илэрхийлэгдэхгүй байх эрсдэлийг үүсгэж байна.

### БУСАД МЭДЭЭЛЭЛ

Удирдлага бусад мэдээллийн талаар хариуцлага хүлээнэ. Бусад мэдээлэл нь жилийн тайланд орсон мэдээллээс бүрддэг боловч түүнд санхүүгийн тайлан багтаагүй байна. Бидний санхүүгийн тайланд өгсөн дүгнэлт нь бусад мэдээлэлд хамаарахгүй ба бид уг мэдээлэлд аливаа баталгаа илэрхийлээгүй.

“Улс төрийн намын тухай” хууль 2023 оны 07 дугаар сарын 07-ны өдөр шинэчлэн найруулагдсан бөгөөд тус хуулийн шинэчлэн найруулсан хувилбарыг 2024 оны 01 дүгээр сарын 01-ээс эхэлж улс төрийн намын үйл ажиллагаа явуулдаг байгууллагад мөрдөх үүрэгтэй. 2023 оны нэгтгэсэн санхүүгийн тайланд хийсэн аудитын тайланг тус хуулийн өмнөх хувилбарт нийцүүлэн бэлтгэсэн болно.

### УДИРДЛАГА БОЛОН ЗАСАГЛАХ ЭРХ БҮХИЙ ЭТГЭЭДҮҮДИЙН САНХҮҮГИЙН ТАЙЛАНД ХҮЛЭЭХ ҮҮРЭГ ХАРИУЦЛАГА

Удирдлага нь эдгээр санхүүгийн тайлангуудыг Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандартын Нягтлан Бодох Бүртгэлийн Стандартуудын дагуу үнэн зөв бэлтгэж, тайлагнах үүрэгтэй бөгөөд мөн залилан эсвэл алдаанаас үүдэх материаллаг алдаатай тайлагналгүй санхүүгийн тайлангуудыг бэлтгэх боломжтой болгоход зайлшгүй чухал гэж өөрийн тодорхойлсон дотоод хяналтуудын талаарх хариуцлагыг хүлээнэ.

Удирдлага нь санхүүгийн тайланг гаргахдаа байгууллагын үйл ажиллагааг зогсоох юм уу татан буулгахаар төлөвлөсөн эсвэл ингэхээс өөр бодит сонголт байхгүй байхаас бусад тохиолдолд санхүүгийн тайлангаа гаргахдаа тасралтгүй байх зарчмын дагуу зогсолтгүй үйл ажиллагаа явуулах байгууллагын чадамжийг үнэлэх, боломжтой бол тасралтгүй байх зарчимтай холбоотой асуудлуудыг тодруулах, нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх суурийг хэрэглэх үүрэг, хариуцлагыг хүлээнэ. Засаглах эрх бүхий этгээдүүд нь байгууллагын санхүүгийн тайлагналын үйл явцад хяналт тавих үүрэг хариуцлагатай байна.

## **НЭГТГЭСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТАД ХҮЛЭЭХ АУДИТОРЫН ҮҮРЭГ ХАРИУЦЛАГА**

Залилан эсвэл алдаанаас үүссэн материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан нь бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй нотолгоо олж авах, дүгнэлт бүхий аудиторын тайлан гаргах нь бидний зорилго юм. Үл үндэслэлтэй нотолгоо гэдэг нь өндөртүвшний нотолгоо боловч АОУС-ын дагуу хийгдсэн аудитаар байгаа материаллаг буруу илэрхийллийг байнга илрүүлдэг гэсэн нотолгоо болохгүй. Буруу илэрхийлэх явдал нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох ба хэрэв тэр нь дангаараа эсвэл нийтдээ санхүүгийн тайланд үндэслэн гаргасан хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх магадлалтай бол материаллагт тооцогддог.

АОУС-ын дагуу аудитын нэг хэсэг байдлаар бид мэргэжлийн шийдэл ашиглаж, аудитын ажлын явцад мэргэжлийн үл итгэх хандлагыг баримтлан ажилладаг. Үүнд:

- 1** Залилан эсвэл алдааны улмаас нэгтгэсэн санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийлэгдэх эрсдэлийг тодорхойлж, түүнийг үнэлэн уг эрсдэлд тохирохуйц аудитын горимыг боловсруулан хэрэгжүүлж өөрсдийн дүгнэлтийнхээ үндэслэл болохуйц хангалттай ба зохистой аудитын баримт нотолгоог олж авдаг. Залилангаас үүссэн материаллаг буруу илэрхийллийг илрүүлэхгүй байх эрсдэл нь алдаанаас үүссэн буруу илэрхийллийг илрүүлэхгүй байх эрсдэлээс харьцангуй их байдаг, учир нь залиланд хуйвалдаан, бичиг баримт хуурамчаар үйлдэх, санаатайгаар орхигдуулах, буруу илэрхийлэх болон дотоод хяналтыг орхигдуулах явдлууд багтсан байж болно.
- 2** Байгууллагын дотоод хяналтын үр ашигтай байдалд дүгнэлт өгөх зорилгоор бус тухайн нөхцөл байдалд тохирохуйц аудитын горим боловсруулахын тулд аудитын ажилтай холбоотой дотоод хяналтын талаар ойлголт олж авдаг ба дотоод хяналтын үр дүнтэй эсэхэд дүгнэлт өгөхгүй.
- 3** Ашиглагдсан нягтлан бодох бүртгэлийн бодлогуудын нийцэмжтэй байдал, нягтлан бодох бүртгэлийн тооцооллын үл үндэслэл, удирдлагын гаргасан холбогдох тодруулгыг үнэлдэг. Нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх суурийг удирдлага зохистой хэрэглэсэн, мөн олж авсан аудитын баримт нотолгоонд үндэслэн байгууллагын тасралтгүй үйл ажиллагаагаа үргэлжлүүлэн явуулах чадамжид мэдэгдэхүйц эргэлзээ үүсгэхүйц үйл явдал, нөхцөл байдалтай холбоотой материаллаг тодорхой бус байдал оршин байгаа эсэхийг тодорхойлдог. Хэрэв материаллаг хэмжээний тодорхой бус байдал оршин байна гэж үзвэл аудиторын тайландаа санхүүгийн тайлангийн холбогдох тодруулгад анхаарал хандуулах эсвэл ийм тодруулга хийх нь хангалтгүй бол дүгнэлтээ өөрчлөх шаардлагатай болдог. Аудиторын тайлан гарах өдөр хүртэлх олж авсан аудитын баримт нотолгоондоо үндэслэн бид дүгнэлтээ гаргадаг. Гэхдээ ирээдүйн үйл явдал, эсвэл нөхцөл байдал байгууллага тасралтгүй байх зарчмын дагуу, үйл ажиллагаагаа үргэлжлүүлэн явуулах боломжгүй болгоход хүргэж болно.
- 4** Тодруулгыг багтаагаад нэгтгэсэн санхүүгийн тайлангийн ерөнхий толилуулга, бүтэц, агуулгыг үнэлж тусдаа санхүүгийн тайланд үнэн зөв толилуулгын шаардлагыг хангахуйц байдлаар гол гол ажил гүйлгээ, үйл явдлуудыг илэрхийлсэн эсэхийг тодорхойлдог.
- 5** Тодруулгыг багтаагаад нэгтгэсэн санхүүгийн тайлангийн ерөнхий толилуулга, бүтэц, агуулгыг үнэлж тусдаа санхүүгийн тайланд үнэн зөв толилуулгын шаардлагыг хангахуйц байдлаар гол гол ажил гүйлгээ, үйл явдлуудыг илэрхийлсэн эсэхийг тодорхойлдог.

Бид бусад асуудлуудын дундаас аудитын ажлын төлөвлөсөн хамрах хүрээ, цаг хугацаа болон аудитын явцад тодорхойлсон дотоод хяналтын аливаа мэдэгдэхүйц доголдлыг багтаагаад аудитын илэрсэн томоохон асуудлуудаар засаглах эрх бүхий этгээдүүдтэй харилцдаг.

Бид мөн засаглах эрх бүхий этгээдүүдэд хараат бус байдлын талаарх холбогдох ёс зүйн шаардлагуудыг мөрдөж ажилласан болох мэдэгдлийг гаргаж өгсөн. Мөн бид хараат бус байдлаа хадгалахын тулд анхаарвал зохих харилцаа болон бусад асуудлын талаар засаглах эрх бүхий этгээдүүдэд мэдэгдсэн.

Засаглах эрх бүхий этгээдүүдтэй харилцсан мэдээллүүдээс санхүүгийн тайлангийн аудитын хамгийн ач холбогдолтой гэж үзсэн асуудлыг аудитын гол асуудлаар сонгож аудиторын тайлангийн "Гол асуудал" хэсэгт оруулсан. Бид аудиторын тайланд тусгасан эдгээр асуудлууд нь хууль тогтоомж, дүрэм журмаар хориглосон гэж үзээгүй тул оруулсан болно.

## БУСАД

Энэхүү тайланг 2005 оны 1 дүгээр сарын 28-ны өдөр батлагдсан "Улс төрийн намын тухай" хуулийн 20 дугаар зүйлд заасны дагуу Монгол Ардын Намын Удирдах Зөвлөлд зориулан бэлтгэсэн ба тайлангийн агуулгын хүрээнд өөр аливаа гуравдагч талын өмнө ямар нэг хариуцлага хүлээхгүй.

Хүндэтгэсэн,

"ИНТЕР АУДИТ" ХХК  
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ

Тайлангийн огноо: 2024/03/12



**2023 ОНЫ АУДИТ ХИЙСЭН  
НЭГТГЭСЭН САНХҮҮГИЙН  
ТАЙЛАН**

**2**

## АУДИТ ХИЙСЭН НЭГТГЭСЭН САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

/Төгрөгөөр/

ҮЗҮҮЛЭЛТ	Тод	2022.12.31	2023.12.31
<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГӨ</b>			
Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө	4	357,897,752.95	1,038,915,465.20
Дансны авлага	5	538,155,405.87	460,519,955.41
Татвар, НДШ-ийн авлага		-	-
Бараа материал	6	86,175,515.25	76,953,831.30
Урьдчилж төлсөн зардал/тооцоо		-	-
Бусад эргэлтийн хөрөнгө	7	7,086,386.00	20,444,963.00
<b>Эргэлтийн хөрөнгийн дүн</b>		<b>989,315,060.07</b>	<b>1,596,834,214.91</b>
<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГӨ</b>			
Үндсэн хөрөнгө	8	31,602,889,812.83	31,377,169,214.83
Хуримтлагдсан элэгдэл – Үндсэн хөрөнгө	8	(69,116,430.68)	(69,116,430.68)
Дуусаагүй барилга		-	-
Мал амьтад		-	-
Биет бус хөрөнгө	9	75,002,540.00	75,742,540.00
<b>Эргэлтийн бус хөрөнгийн дүн</b>		<b>31,608,775,922.15</b>	<b>31,383,795,324.15</b>
<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН</b>		<b>32,598,090,982.22</b>	<b>32,980,629,539.06</b>
<b>ӨР ТӨЛБӨР</b>			
<b>БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>			
Дансны өглөг	10	247,981,888.74	248,189,488.74
Цалингийн өглөг	11	58,577,537.47	60,980,011.11
ХХОАТ-ын өглөг	12	289,628,120.90	192,242,765.86
НДШ-ийн өглөг	13	170,451,540.55	126,328,634.84
Бусад өглөг	14	1,569,696,880.00	1,586,698,321.00
Урьдчилж орсон орлого		-	-
<b>Богино хугацаат өр төлбөрийн дүн</b>		<b>2,336,335,967.66</b>	<b>2,214,439,221.54</b>
<b>УРТ ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>			
Урт хугацаат зээл		-	-
Бусад урт хугацаат өр төлбөр		-	-
<b>Урт хугацаат өр төлбөрийн дүн</b>		-	-
<b>ӨР ТӨЛБӨРИЙН НИЙТ ДҮН</b>		<b>2,336,335,967.66</b>	<b>2,214,439,221.54</b>
<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ</b>			
Нөөц:			
Хязгаарлалттай	15	18,608,683,245.45	18,608,683,245.45
Хязгаарлалтгүй	15	4,364,511,202.43	4,364,511,202.43
Дахин үнэлгээний нэмэгдэл	15	4,755,617,700.00	4,755,617,700.00
Цэвэр хөрөнгийн бусад хэсэг		-	-
<b>Хуримтлагдсан үр дүн</b>		<b>2,532,942,866.68</b>	<b>3,037,378,169.64</b>
Тайлант үеийн үр дүн	15	(52,332,957.54)	492,317,683.26
Өмнөх үеийн үр дүн	15	2,585,275,824.22	2,545,060,486.38
<b>Цэвэр хөрөнгийн дүн</b>		<b>30,261,755,014.56</b>	<b>30,766,190,317.52</b>
<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР БА ӨМЧИЙН ДҮН</b>		<b>32,598,090,982.22</b>	<b>32,980,629,539.06</b>

Хавсралт, тодруулга нь энэхүү тайлангийн салшгүй хэсэг болно.

ИНТЕР АУДИТ ХХК

№ 01 огноо 2024.03.12

## АУДИТ ХИЙСЭН НЭГТГЭСЭН ОРЛОГЫН ДЭЛГЭРЭНГҮЙ ТАЙЛАН

/Төгрөгөөр/

ҮЗҮҮЛЭЛТ	ТОД	2022.12.31	2023.12.31
<b>1. ҮНДСЭН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГО</b>			
Гишүүдийн татвар	16	1,768,249,551.58	1,892,109,849.00
Хөтөлбөр, төслийн орлого	16	2,199,990,000.00	2,033,095,481.00
Бэлэг, хандив, тусламжийн орлого	16	2,941,494,099.00	333,390,000.00
Түрээсийн орлого	16	1,000,980,500.42	2,608,437,394.00
Бусад орлого	16	-	1,795,665,000.00
<b>ҮНДСЭН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГО</b>		<b>7,910,714,151.00</b>	<b>8,662,697,724.00</b>
<b>2. ҮНДСЭН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДАЛ</b>			
Цалин хөлс шагнал	17	4,013,850,008.20	4,142,223,685.02
Нийгмийн даатгалын шимтгэл	17	495,234,423.90	511,051,318.89
Засвар үйлчилгээний зардал	17	182,674,097.79	171,422,938.70
Ашиглалтын зардал	17	526,830,338.23	492,636,607.66
Түрээсийн зардал	17	47,490,000.00	1,620,000.00
Албан томилолтын зардал	17	16,575,520.00	90,862,630.00
Тээврийн зардал	17	5,331,300.00	3,844,480.00
Түүхий эд материалын зардал	17	292,475,645.44	205,845,264.95
Элэгдлийн зардал	-	-	-
Зар сурталчилгааны зардал	17	7,587,184.00	58,848,000.00
Шуудан, холбооны зардал	17	65,143,262.42	78,260,045.83
Шатахууны зардал	17	106,174,160.00	170,187,926.00
Найдваргүй авлагын зардал	-	-	-
Шагнал, урамшууллын зардал	17	261,829,833.00	406,651,000.00
Зээлийн хүүгийн зардал	-	-	-
Бусад зардал	17	1,716,685,614.25	1,485,975,838.79
<b>Үйл ажиллагааны зардлын дүн</b>	-	<b>7,737,881,387.23</b>	<b>7,819,429,735.84</b>
<b>ҮНДСЭН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН</b>	-	<b>172,832,763.77</b>	<b>843,267,988.16</b>
<b>3. ҮНДСЭН БУС ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН</b>			
Туслах үйлдвэрлэл, үйлчилгээний ашиг (алдагдал)	-	-	-
Торгууль, хөнгөлөлтийн ашиг (алдагдал)	-	-	-
Татварын зардал	-	-	-
Бусад	-	(225,165,721.31)	(350,950,304.90)
<b>ТАЙЛАНТ ҮЕИЙН ҮР ДҮН</b>	-	<b>(52,332,957.54)</b>	<b>492,317,683.26</b>

Хавсралт, тодруулга нь энэхүү тайлангийн салшгүй хэсэг болно.

ИНТЕР АУДИТ ХХК

№ 01 огноо 2024.03.12

## АУДИТ ХИЙСЭН НЭГТГЭСЭН ЦЭВЭР ХӨРӨНГИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН

ҮЗҮҮЛЭЛТ	/Төгрөгөөр/					
	ХЯЗГААРЛАЛТТАЙ НӨӨЦ	ХЯЗГААРЛАЛТГУЙ НӨӨЦ	ДАХИН ҮНЭЛГЭЭНИЙ НЭМЭГДЭЛ	ЦЭВЭР ХӨРӨНГИЙН БУСАД ХЭСЭГ	ХУРИМТЛАГДСАН ҮР ДҮН	НИЙТ ДҮН
<b>2021 оны 12 сарын 31-ний үлдэгдэл</b>	18,549,886,764.45	4,043,307,683.43	4,755,617,700.00	-	2,543,823,783.73	29,892,635,931.61
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга	-	-	-	-	41,452,040.49	41,452,040.49
<b>ЗАЛРУУЛСАН ҮЛДЭГДЭЛ</b>	18,549,886,764.45	4,043,307,683.43	4,755,617,700.00	-	2,585,275,824.22	29,934,087,972.10
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	-	-	-	-	(52,332,957.54)	(52,332,957.54)
Бусад дэлгэрэнгүй орлого	-	-	-	-	-	-
Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз	-	380,000,000.00	-	-	-	380,000,000.00
Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн	-	-	-	-	-	-
<b>2022 оны 12 сарын 31-ний үлдэгдэл</b>	18,549,886,764.45	4,423,307,683.43	4,755,617,700.00	-	2,532,942,866.68	30,261,755,014.56
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга	58,796,481.00	(58,796,481.00)	-	-	12,117,619.70	12,117,619.70
<b>ЗАЛРУУЛСАН ҮЛДЭГДЭЛ</b>	18,608,683,245.45	4,364,511,202.43	4,755,617,700.00	-	2,545,060,486.38	30,273,872,634.26
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	-	-	-	-	492,317,683.26	492,317,683.26
Бусад дэлгэрэнгүй орлого	-	-	-	-	-	-
Өмчид гарсан өөрчлөлт	-	-	-	-	-	-
Зарласан ногдол ашиг	-	-	-	-	-	-
Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн	-	-	-	-	-	-
<b>2023 ОНЫ 12 САРЫН 31-НИЙ ҮЛДЭГДЭЛ</b>	18,608,683,245.45	4,364,511,202.43	4,755,617,700.00	-	3,037,378,169.64	30,766,190,317.52

Хавсралт, тодруулга нь энэхүү тайлангийн салшгүй хэсэг болно.

## АУДИТ ХИЙСЭН НЭГТГЭСЭН МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН

/Төгрөгөөр/

ҮЗҮҮЛЭЛТ	2022.12.31	2023.12.31
<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>		
<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГО</b>	<b>8,603,572,051.02</b>	<b>9,675,474,580.62</b>
Гишүүдийн татвараас орсон мөнгө	2,595,832,086.54	2,344,654,883.60
Төсөл, хөтөлбөрөөс хүлээн авсан мөнгө	976,400,000.00	473,912,148.00
Бэлэг, хандив, тусламж	2,801,524,999.00	311,098,000.00
Түрээсийн орлогод хүлээн авсан мөнгө	1,165,407,770.00	2,418,492,417.00
Бусад	1,064,407,195.48	4,127,317,132.02
<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ЗАРЛАГА</b>	<b>8,899,913,085.47</b>	<b>8,958,786,868.37</b>
Ажиллагчдад олгосон мөнгө	3,285,622,830.08	3,577,305,230.54
Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн мөнгө	815,283,033.18	935,155,962.86
Бараа материал худалдан авахад төлсөн мөнгө	1,649,192,340.57	2,544,627,008.18
Ашиглалтын зардалд төлсөн мөнгө	766,327,524.78	500,998,726.51
Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн мөнгө	120,153,548.00	155,200,631.70
Бэлтгэн нийлүүлэгчдэд төлсөн бусад мөнгө	1,886,900,965.31	832,754,787.75
Төлсөн хүү	-	1,442,728.45
Төлсөн татвар	321,881,204.55	398,395,144.38
Даатгалын төлбөрт төлсөн мөнгө	54,551,639.00	12,906,648.00
<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>	<b>(296,341,034.45)</b>	<b>716,687,712.25</b>
<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГО</b>		
Үндсэн хөрөнгө борлуулсны орлого	-	-
Биет бус хөрөнгө борлуулсны орлого	-	-
Хөрөнгө оруулалт борлуулсны орлого	-	-
<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ЗАРЛАГА</b>		
Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	-	-
Биет бус хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	-	-
Хөрөнгө оруулалт олж эзэмшихэд төлсөн	5,500,000.00	35,670,000.00
<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>	<b>(5,500,000.00)</b>	<b>(35,670,000.00)</b>
<b>САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>		
Банкнаас авсан зээл /хувь хүн/	-	-
Санхүүгийн түрээсийн өглөгийн төлбөр	-	-
Зээлийн төлөлт	-	-
Улсаас өгсөн санхүүжилт	344,532,405.00	-
Урт хугацаат өрийн тайлангийн хугацааны төлөлт	-	-
Хүү ба урамшууллын орлого	-	-
<b>САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>	<b>344,532,405.00</b>	<b>-</b>
<b>Валютын ханшийн зөрүү</b>	<b>-</b>	<b>-</b>
<b>БҮХ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>	<b>42,691,370.55</b>	<b>681,017,712.25</b>
Мөнгө түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	<b>315,206,382.40</b>	<b>357,897,752.95</b>
Мөнгө түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	<b>357,897,752.95</b>	<b>1,038,915,465.20</b>

Хавсралт, тодруулга нь энэхүү тайлангийн салшгүй хэсэг болно.

САНХҮҮГИЙН  
ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3

“Монгол Ардын Нам” ТББ-ын 2023 оны жилийн эцсийн нэгтгэсэн санхүүгийн  
тайланд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

## 1. ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ БА ҮНДСЭН ҮЙЛ АЖИЛЛАГАА

"Монгол Ардын Нам" ТББ (Цаашид "МАН" гэх) нь Монгол Ардын Хувьсгалт Намын зүй ёсны эхлэл ба үе залгамжлалын үргэлжлэл бөгөөд Монгол Улсын холбогдох хууль тогтоомжийн дагуу 1921 онд улс төрийн намын үйл ажиллагааг явуулахаар байгуулагдсан. Монгол Ардын Нам нь өнөөгийн байдлаар 283 мянга гаруй гишүүдийг эгнээндээ нэгтгэсэн 330 сумдын намын үүргийг хамарсан 21 аймаг, нийслэл, 9 дүүргийн анхан шатны намын хороодоос бүрдсэн Монгол улсын улс төрийн ууган байгууллага болон хөгжсөн. Улсын бүртгэлийн албанаас (хуучин нэрээр) 2009 оны 01 дүгээр сарын 07-ны өдөр 8488908 тоот регистртэй, 9019045039 тоот улсын бүртгэлийн дугаартай гэрчилгээг олгосон байна.

Монгол Ардын Нам нь Монгол Улсын тусгаар тогтнол, хүний эрх, эрх чөлөө, шударга ёс, эв санааны нэгдэл, үндэсний язгуур эрх ашгийг эрхэмлэн дээдэлсэн, социал демократ үзэл баримтлал бүхий улс төрийн байгууллага болно.

Монгол Ардын Намын эрхэм зорилго, хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд өөрийн гишүүдээ оролцуулах, дэмжих, намын үзэл баримтлал, үйл хэргийг сурталчлан таниулах, судалгаа шинжилгээ хийх, иргэдэд тустай олон нийтийн ажилд оролцох чиглэлээр 6 төрийн бус байгууллагууд үйл ажиллагаа явуулж байна.

Монгол Ардын Намын Удирдах Зөвлөлийн ажлын алба нь 2023 онд Намын байгуулалтын газар, Хэвлэл мэдээллийн газар, Сан хөрөнгийн газар гэсэн 3 газар, тэдгээр харьяалагдах 7 хэлтэс, 2 алба, 140 гаруй үндсэн болон гэрээт ажиллагсадтай үйл ажиллагаагаа явуулж байна.

МАН-ын албан ёсны хаяг: Монгол Улс, Улаанбаатар хот 11, Сүхбаатар дүүрэг, 6 дугаар хороо, Бага тойруу, МАН-ын төв байр 1, Тусгаар тогтнолын ордон.

## 2. САНХҮҮГИЙН ТАЙЛАГНАЛЫН СУУРЬ ЗАРЧИМ

### НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН ҮНДЭС:

Монгол Ардын Намын нэгтгэсэн санхүүгийн тайлан нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандартын Нягтлан Бодох Бүртгэлийн Стандартуудад нийцүүлэн Сангийн сайд болон бусад холбогдох эрх бүхий байгууллагаас гаргасан журам, аргачлалын дагуу бэлтгэгдсэн. Мөн, МАН нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулиас гадна Татварын ерөнхий хууль, Нийгмийн даатгалын ерөнхий хууль болон бусад хуулиуд, Сангийн сайдын 2017 оны 286 дугаар тушаалаар баталсан "Төрийн бус байгууллагын санхүүгийн тайлан бэлтгэх, боловсруулах журам, аргачлалыг мөрдлөг болгосон байна.

### ҮНЭЛГЭЭ:

МАН нь санхүүгийн тайланд хөрөнгө, өр төлбөрийг түүхэн өртгийн зарчмаар хэмжиж бүртгэсэн. МАН нь үндсэн хөрөнгөө дахин үнэлгээний зарчмын дагуу бүртгэдэг. Зарим хөрөнгө, өр төлбөрүүдийг бодит үнэ цэнээр нь хэмждэг. Бодит үнэ цэн гэж хэмжилтийн өдөр зах зээлд оролцогчдын хоорондох ердийн ажил гүйлгээгээр хөрөнгийг шилжүүлснээр хүлээн авах, эсвэл өр төлбөрийг барагдуулснаар төлөх дүнг хэлнэ. Бодит үнэ цэнийн хэмжилт, тодруулгын хувьд СТОУС 13 Бодит үнэ цэнийн хэмжилтийг мөрддөг. Бодит үнэ цэнийг тооцоолоход ашигласан мэдээллийг найдвартай байдлаар нь дараах 3-н түвшинд хуваадаг:

Түвшин 1: Хэмжилтийн өдрөөрх ижил төстэй, хязгаарлалтгүй хөрөнгө эсвэл төлбөрийн идэвхтэй зах зээл дээрх олж болохуйц тохируулга хийгдээгүй, жишиг үнэ.

Түвшин 2: Хэмжилтийн өдрөөрх ижил төстэй хөрөнгө эсвэл төлбөрийн жишиг үнээс бусад олж авч болохуйц орц мэдээллүүд, эсвэл идэвхтэй бус зах зээл дээрх ижил төстэй хөрөнгө, өр төлбөрийн тогтсон үнэ, эсвэл тухайн хөрөнгө, өр төлбөрийн хувьд бараг бүхэлд нь олж авч болохуйц зах зээлийн өгөгдөл, мэдээллээс тооцож болохуйц орц мэдээлэл.

Түвшин 3: Тухайн хөрөнгө, өр төлбөрийн үнийг тогтоохдоо зах зээлд оролцогчдын ашигладаг төсөөллийг удирдлага ашиглан тооцсон тооцооллыг илэрхийлдэг орц мэдээлэл.

**САНХҮҮГИЙН ТАЙЛАНГ БЭЛТГЭСЭН ВАЛЮТ:**

МАН-ын ажил гүйлгээний хэмжих нэгж нь Монгол Улсын үндэсний мөнгөн тэмдэгт - төгрөг (MNT) юм. НББОУС 21 Гадаад Валютын Ханшийн Өөрчлөлтийн Үр Нөлөөнд Санхүүгийн тайланг толилуулж буй валютын толилуулгын валют гэж заасан байдаг. Мөн Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 7.2 дахь "Монгол Улсын нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгж, байгууллага ажил, гүйлгээгээ үндэсний мөнгөн тэмдэгтээр бүртгэж, тайлагнана" гэж заасны дагуу Компани нь санхүүгийн тайлан, тодруулгаа төгрөгөөр бэлтгэсэн.

**НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН СУУРЬ:**

Санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн аккруэл суурьт зарчимд үндэслэн бэлтгэдэг. Ингэхдээ, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 6.1 дэх "Аж ахуйн нэгж, байгууллага нягтлан бодох бүртгэлээ аккруэл сууриар хөтөлнө" гэж заасныг мөрдлөг болгосон.

**САНХҮҮГИЙН ТАЙЛАН БЭЛТГЭСЭН ТӨСӨӨЛӨЛ:**

Мөрдөж байгаа хууль эрх зүйн болон бизнесийн орчинд компанийн цаашдын үйл ажиллагаанд нөлөөлөхүйц өөрчлөлт орох хандлага ба төсөөлөлгүй байна. МАН-ын Удирдах зөвлөл болон хороодын удирдлага нь МАН-ыг татан буулгах, эсвэл үйл ажиллагааг нь зогсоохоор санаархаж байгаа эсвэл тэгэхээс өөр ямар ч бодит боломжгүй байхаас бусад тохиолдолд ерөнхий зорилготой, олон нийтэд нээлттэй толилуулах нэгтгэсэн санхүүгийн тайлангуудыг тасралтгүй байх зарчмын дагуу бэлтгэдэг. Тайлант онд МАН-ын үйл ажиллагааны тасралтгүй байдалтай холбоотой ямар нэгэн эргэлзээтэй үйл явдал үүсээгүй.

**НЭГТГЭСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН СУУРЬ:**

МАН-ын Удирдах зөвлөл нь төсөөтэй нөхцөл байдал дахь ижил гүйлгээ ба бусад үйл явдлын хувьд нэгдмэл нягтлан бодох бүртгэлийн бодлого баримталснаар нэгтгэсэн санхүүгийн тайланг гаргана. МАН нь 2005 оны 1 дүгээр сарын 28-ны өдөр баталсан "Улс төрийн намын тухай" хуулийн 20.2 дугаар заалтыг хэрэгжүүлэх зорилгоор МАН-ын Удирдах Зөвлөл нь харьяа байгууллагуудын санхүүгийн тайланг гаргасны дараа нэгтгэсэн санхүүгийн тайланг гаргадаг.

МАН-ын нэгтгэсэн санхүүгийн тайлан нь МАН-ын Удирдах Зөвлөлийн ажлын алба болон намын Хяналтын зөвлөлийн хяналтад байдаг нийслэл, аймаг, сум, дүүргийн намын хороод, анхан шатны байгууллагуудын тусдаа санхүүгийн тайлангуудын нэгдлээс бүрддэг.

Хяналт байгаа эсэхийг хяналтын загварын үндсэн дараах гурван элементийг бүгдийг нь зэрэг агуулсан эсэхийг үнэлж тодорхойлно. Үүнд:

- Санхүүжигчид үзүүлэх нөлөө,
- Санхүүжигчийн өгөөжөөс хүртэх эрх,
- Санхүүжигчийн өгөөжөөс хүртэх дүнд нөлөөлөх чадвар зэрэг болно.

МАН-ын Удирдах Зөвлөл нь санхүүжигчид хяналт тогтоож байгаа эсэхийг дээрх гурван элементүүдэд өөрчлөлт гарсан эсэхээр тайлант хугацаа бүрийн эцэст дахин хянаж үнэлдэг.

МАН-ын Удирдах Зөвлөл нь аймаг, нийслэлийн намын хороодыг хяналтдаа авсан өдрөөс эхлэн нэгтгэсэн санхүүгийн тайланд уг намын хороодыг нэгтгэх ба хороонд тавих хяналтаа алдсан өдрөөс эхлэн нэгтгэл хийхийг зогсоодог. Аймаг, нийслэлийн намын хороодын тайлант жилийн орлого, зардлыг нэгтгэсэн санхүүгийн тайланд тусгахдаа тухайн намын хороон дахь хяналтыг олж авсан өдрөөс тухайн намын хороон дахь хяналтаа алдсан өдөр хүртэлх тайлант жилийн орлого, зардлыг ашиг алдагдал болон бусад үзүүлэлтийг нэгтгэсэн иж бүрэн орлого үр дүнгийн тайланд тусгадаг.

Хэрэв шаардлагатай бол, МАН-ын Удирдах зөвлөл нь өөрийн үндсэн нягтлан бодох бүртгэлийн бодлоготой нийцүүлэхийн тулд аймаг, нийслэлийн намын хороодын тусдаа санхүүгийн тайланд тохируулга хийж болно.

МАН-ын Удирдах Зөвлөл болон аймаг, нийслэлийн намын хороодын хооронд хийгдсэн орлого зардал, мөнгөн гүйлгээ болон хөрөнгө, өр төлбөр, өмчийн дансдын үлдэгдлийг нэгтгэсэн санхүүгийн тайланд бүрэн устгадаг байна.

МАН-ын Удирдах Зөвлөлийн нэгтгэсэн санхүүгийн тайланд дараах аймаг, нийслэл, дүүргийн намын хороодын 2023 оны жилийн эцсээр гаргасан гүйлгээ балансаар үлдэгдлийг нэгтгэсэн болно. Үүнд:

1. МАН-ын Удирдах Зөвлөлийн Ажлын албаны,
2. Нийслэлийн (Улаанбаатар) намын хороо, түүний бүтцэд Багануур, Багахангай, Баянгол, Баянзүрх, Чингэлтэй, Налайх, Сонгинохайрхан, Сүхбаатар, Хан-Уул дүүргүүдийн намын хороодын,
3. Архангай, Баян-Өлгий, Баянхонгор, Булган, Говь-Алтай, Говьсүмбэр, Дархан-Уул, Дорноговь, Дорнод, Дундговь, Завхан, Орхон, Өвөрхангай, Өмнөговь, Сүхбаатар, Сэлэнгэ, Төв, Увс, Ховд, Хөвсгөл, Хэнтий аймгуудын намын хороодын зэрэг болно.

### СТОУС-ЫН ӨӨРЧЛӨЛТ, ШИНЭЧЛЭЛТ:

2021 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн хүчин төгөлдөр болсон, СТОУС-ын нэмэлт өөрчлөлтүүдээс бусад нягтлан бодох бүртгэлийн бодлогуудыг өмнөх санхүүгийн жилүүдэд тууштай хэрэгжүүлсэн. Дараах өөрчлөлтүүд СТОУС-д орсон ба тайлант үе болон дараагийн тайлант үеүдэд мөрдөгдөхөөр байна:

СТОУС 3-т орсон нэмэлт өөрчлөлт: Бизнесийн тодорхойлолт: СТОУС 3 Бизнесийн нэгдэлд оруулсан нэмэлт өөрчлөлтөөр бизнес нь дор хаяж үйл ажиллагаа болон хөрөнгийн цогцдоо эцсийн бүтээгдэхүүнийг гаргах чадамжид их хэмжээгээр нөлөөлж чадахуйц орц болон бодит үйл явцын нэгдлийг багтаасан байх ёстой. Цаашилбал, бизнес нь эцсийн бүтээгдэхүүнийг бий болгоход шаардагдах бүх орц болон процесстэйгээр оршин тогтнох шаардлагагүй болохыг тодруулсан болно. Уг нэмэлт өөрчлөлт Компанийн санхүүгийн тайланд нөлөөгүй боловч Компани ирээдүйд аливаа бизнесийн нэгдэлд орох тохиолдолд нөлөөлж болзошгүй юм.

СТОУС 3-т орсон нэмэлт өөрчлөлт: Бизнесийн тодорхойлолт: СТОУС 3 Бизнесийн нэгдэлд оруулсан нэмэлт өөрчлөлтөөр бизнес нь дор хаяж үйл ажиллагаа болон хөрөнгийн цогцдоо эцсийн бүтээгдэхүүнийг гаргах чадамжид их хэмжээгээр нөлөөлж чадахуйц орц болон бодит үйл явцын нэгдлийг багтаасан байх ёстой. Цаашилбал, бизнес нь эцсийн бүтээгдэхүүнийг бий болгоход шаардагдах бүх орц болон процесстэйгээр оршин тогтнох шаардлагагүй болохыг тодруулсан болно. Уг нэмэлт өөрчлөлт Компанийн санхүүгийн тайланд нөлөөгүй боловч Компани ирээдүйд аливаа бизнесийн нэгдэлд орох тохиолдолд нөлөөлж болзошгүй юм.

НББОУС 1, НББОУС 8-д орсон нэмэлт өөрчлөлт: Материаллаг байдлын тодорхойлолт: Нэмэлт өөрчлөлт нь "Материаллаг"-г шинэ тодорхойлолтыг: "Тайлагнагч байгууллагын санхүүгийн тайланд аливаа мэдээллийг орхигдуулах, эсвэл буруу ташаа, тодорхой бус байдлаар илэрхийлэх нь байгууллагын санхүүгийн тайлангийн үндсэн хэрэглэгчдийн уг тайланг үндэслэн гаргах шийдвэрт үндэслэлтэйгээр нөлөөлж болзошгүй тохиолдолд тухайн мэдээллийг материаллаг гэж үзнэ." гэжээ. Нэмэлт өөрчлөлтүүд нь "материаллаг"-г санхүүгийн тайлангийн агуулгаар, тухайн мэдээллийн шинж чанар ба/эсвэл хэмжээгээс хамаарна гэдгийг тодорхойлсон. Мэдээллийг буруу ташаа илэрхийлэх нь үндсэн хэрэглэгчдийн гаргах шийдвэрт үндэслэлтэйгээр нөлөөлөхүйц бол үүнийг материаллаг гэж үзнэ. Эдгээр нэмэлт, өөрчлөлт нь санхүүгийн тайланд нөлөөлөөгүй бөгөөд цаашид Компанид нөлөөлөхгүй гэж үзэж байна.

2018 оны 3 дугаар сарын 29-ний өдөр гаргасан Санхүүгийн тайлагналын суурь үзэл баримтлал: СТОУС 16-д орсон нэмэлт өөрчлөлт: Ковид-19-тэй холбоотой түрээсийн хөнгөлөлт 2020 оны 5 дугаар сарын 28-нд НББОУС3 нь Ковид-19-тэй холбоотой түрээсийн хөнгөлөлтийн тухай СТОУС 16 Түрээс-д нэмэлт, өөрчлөлт оруулсан. Нэмэлт өөрчлөлтүүд нь түрээслэгчдэд Ковид-19 цар тахлын шууд үр дагавраас үүдэлтэй түрээсийн хөнгөлөлтийг бүртгэх түрээсийн өөрчлөлтийн бүртгэлийн талаарх СТОУС 16-ийн зааврыг хэрэгжүүлэхэд хөнгөлөлт үзүүлдэг. Энэхүү хөнгөлөлтийн зорилго нь түрээслэгч нь түрээслүүлэгчээс Ковид-19-тэй холбоотой авсан түрээсийн хөнгөлөлтийг түрээсийн өөрчлөлт мөн эсэхийг үнэлэхгүй байж болох сонголтыг оруулж өгсөн. Энэ сонголтыг хийсэн түрээслэгч нь Ковид-19-тэй холбоотой түрээсийн хөнгөлөлтийг СТОУС 16-д заасан түрээсийн өөрчлөлт гэж үзээгүй үед тооцсонтой адил аргаар тооцно. Энэхүү нэмэлт өөрчлөлт нь 2020 оны 6 дугаар сарын 1-ний өдрөөс хойших жилийн тайлангийн хугацаанд хамаарна. Эрт хэрэгжүүлж эхлэхийг зөвшөөрнө.

Компани түрээслүүлэгчийн хувьд зөвхөн нэг л төрлийн түрээсийн гэрээ байгуулсан тул СТОУС 16-д оруулсан нэмэлт өөрчлөлтүүд нь Компанийн санхүүгийн тайланд мэдэгдэхүйц нөлөө үзүүлээгүй болно.

Компанийн санхүүгийн тайлангуудыг бэлтгэж гаргах өдрийн байдлаар батлагдаж гарсан боловч хэрэгжиж эхлээгүй стандартуудыг доор үзүүлэв. Компани энэхүү стандартуудыг (хэрэв Компанид хамааралтай бол) хүчин төгөлдөр үйлчилж эхлэх өдрөөс мөрдөх хандлагатай байна.

НББОУС 1-т орсон нэмэлт өөрчлөлт - Эргэлтийн болон эргэлтийн бус өр төлбөрийн ангилал 2

СТОУС 3-т орсон нэмэлт өөрчлөлт - Үзэл баримтлалын хүрээний тайлбар 1

НББОУС 16-д орсон нэмэлт өөрчлөлт - Үндсэн хөрөнгө: Зориулалтаар ашиглаж эхлэхээс өмнөх орлого 1

НББОУС 37-д орсон нэмэлт өөрчлөлт - Онцгой гэрээ – Гэрээний үүрэг биелүүлэх зардал 1

СТОУС 1 СТОУС-ыг анхлан хэрэгжүүлэх - Охин компани нь анхлан хэрэгжүүлэгч 1

НББОУС 41 Газар тариалан - Бодит үнэ цэнийн хэмжилтэд татвар ногдуулах тухай.

### **3. НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН ҮНДСЭН БОДЛОГУУД**

Компани нь санхүүгийн тайлангаа бэлтгэхдээ СТОУС-ыг мөрдлөг болгосон. Тайлант онд дараах нягтлан бодох бүртгэлийн бодлогуудын дагуу санхүүгийн тайлангаа толилуулсан байна.

#### **МӨНГӨ, ТҮҮНТЭЙ АДИЛТГАХ ХӨРӨНГӨ**

НББОУС 7 Мөнгөн Гүйлгээний Тайлан-д заасны дагуу Компанийн мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө нь касс болон харилцах дансанд байгаа бэлэн мөнгө, үнэ цэнийн өөрчлөлтийн маш бага эрсдэл бүхий, тогтсон мөнгөн дүнд хөрвөх чадвар сайтай богино хугацаат хөрөнгө оруулалтуудаас бүрдэж байна. Мөнгө ба түүнтэй адилтгах зүйлсийг нэрлэсэн үнээр нь бүртгэдэг. Тайлант үеийн эцэст гадаад валютаарх мөнгөн хөрөнгийн үлдэгдлийг Монголбанкнаас зарласан хаалтын ханшаар төгрөгт хөрвүүлдэг ба үүссэн ханшийн зөрүүгийн олз, гарзыг тайлант үеийн ашиг, алдагдлаар хүлээн зөвшөөрдөг.

#### **ГАДААД ВАЛЮТЫН БҮРТГЭЛ**

Санхүүгийн тайланг Монгол төгрөгөөр илэрхийлсэн бөгөөд компани үйл ажиллагаагаа явуулдаг албан ёсны мөнгөн тэмдэгт нь Монголулсын мөнгөн тэмдэгт - Монгол төгрөг (MNT) юм. Гадаад улс орны валютаар илэрхийлэгдсэн хөрөнгө, өр төлбөр, гүйлгээг тайлан гаргасан өдрийн Монгол банкнаас зарласан албанханшаар төгрөгт хөрвүүлж санхүүгийн тайланд тусгана.

Хөрвүүлэлтээс үүссэн гадаад валютын ханшийн зөрүүг орлого үр дүнгийн тайланд ашиг (алдагдал)-аар хүлээн зөвшөөрнө. Гадаад валютаар илэрхийлэгдсэн мөнгөн бус зүйлсийг нэрлэсэн үнээр нь бүртгэдэг бөгөөд нэрлэсэн үнийг тухайн өдрийн ханшаар хөрвүүлэн бүртгэлд тусгана.

#### **САНХҮҮГИЙН ХӨРӨНГӨ**

##### **Анхдагч хүлээн зөвшөөрөлт**

Санхүүгийн хөрөнгийг анх удаа түүний бодит үнэ цэнээр нь хүлээн зөвшөөрөх ба бодит үнэ цэнийн өөрчлөлт нь ашиг, алдагдлаар хэмжигдэх санхүүгийн хөрөнгөөс бусад хөрөнгийн хувьд анхдагч шууд зардлыг бодит үнэ цэнийн хэмжилт дээр нэмж тооцдог. Ашиг, алдагдлаарх бодит үнэ цэнээр хэмжигдэх санхүүгийн хөрөнгийн анхдагч шууд зардал (гүйлгээний шимтгэл гэх мэт ажил гүйлгээний зардал)-ыг тайлант үеийн ашиг, алдагдлаар хүлээн зөвшөөрнө.

##### **Ангилал**

*Хорогдуулсан өртгөөр хэмжсэн санхүүгийн хөрөнгө* - Гэрээний мөнгөн урсгалыг хүлээн авах зорилгоор эзэмшиж буй бизнесийн загвар бүхий санхүүгийн хөрөнгүүдийг энэ ангилалд хамруулна. Гэрээний нөхцөлийн дагуу тодорхойлсон өдрүүдэд үндсэн төлбөр болон үлдэгдэл төлбөрөөс бодогдсон хүүг хүлээн авах эрх бий болно. Зээл болон авлагууд нь идэвхтэй зах зээл дээрх жишиг үнэгүй, тогтмол эсвэл тодорхойлж болох төлбөртэй, үүсмэл биш санхүүгийн хөрөнгүүд хамаарна. Дансны авлага нь үндсэн үйл ажиллагааны явцад зээлээр борлуулсан бараа, бүтээгдэхүүн, үзүүлсэн ажил үйлчилгээний төлөө худалдан авагч болон харилцагчаас авах мөнгөн дүн байна. Дансны авлагыг анх СТОУС 9 Санхүүгийн Хэрэглүүр-ийн 5.1.3-д заасны дагуу СТОУС 15 Худалдан авагчидтай байгуулсан гэрээний орлого-д заасан мэдэгдэхүйц санхүүжилтийн хэлэлцээр агуулаагүй бол ажил гүйлгээ үнээр хэмжинэ.

*Бусад дэлгэрэнгүй орлогоорх бодит үнэ цэнээр хэмжсэн санхүүгийн хөрөнгө* – Санхүүгийн хөрөнгийг гэрээний мөнгөн урсгалыг хүлээн авах болон мөн арилжих зорилгоор эзэмшиж байгаа бол эдгээр

хөрөнгийг бодит үнэ цэнээр бүртгэж, өөрчлөлтийг нь бусад дэлгэрэнгүй орлогоор тайлагнана. Мөн гэрээний нөхцөлийн дагуу тодорхойлсон өдрүүдэд үндсэн төлбөр болон үлдэгдэл төлбөрөөс бодогдсон хүүг хүлээн авах эрх бий болдог санхүүгийн хөрөнгө. Түүнчлэн тогтмол эсвэл тодорхойлж болохуйц төлбөр болон тогтсон хугацаа байхгүй дунд болон урт хугацаанд эзэмшихээр шийдсэн хөрөнгө оруулалтыг энэ ангилалд багтаана.

*Ашиг, алдагдлаарх бодит үнэ цэнээр хэмжсэн санхүүгийн хөрөнгө* - Бодит үнэ цэнд үндэслэн гүйцэтгэлийг нь үнэлж, удирдан зохицуулдаг санхүүгийн хөрөнгийг дээр дурдсан 2 аргын шаардлага хангаагүй тохиолдолд ашиг алдагдлаарх бодит үнэ цэнээр илэрхийлэгдсэн санхүүгийн хөрөнгө гэж үзнэ. Өөрөөр хэлбэл тухайн санхүүгийн хөрөнгийн бодит үнэ цэнийн мэдээлэлд анхаарал хандуулдаг, тухайн хөрөнгийн гүйцэтгэлийг үнэлж, шийдвэр гаргахын тулд уг мэдээллийг ашигладаг, бизнесийн загварын хувьд гэрээний мөнгөн гүйлгээг цуглуулах зорилгоор ч эзэмшдэггүй, мөн гэрээний мөнгөн гүйлгээг цуглуулах ба борлуулах зорилгоор ч эзэмшдэггүй бол энэ аргын дагуу тухайн хөрөнгө оруулалтыг бүртгэнэ. Ийм санхүүгийн хөрөнгийн хувьд гэрээний мөнгөн гүйлгээний цуглуулалт нь тухайн бизнесийн загварын зорилгыг биелүүлэхэд зөвхөн тохиолдлын шинжтэй үйл явдал байдаг. Өөрөөр хэлбэл, арилжааны буюу ашиг олох зорилгоор худалдан авч, богино хугацаанд эргүүлэн худалдах зориулалттай санхүүгийн хөрөнгө хамаарна. Идэвхтэй зах зээлийн жишиг үнэ байхгүй, бодит үнэ цэнийг нь хэмжих боломжгүй, өмчийн хэрэглүүрт оруулсан хөрөнгө оруулалтыг энэ ангилалд хамааруулж ангилахгүй.

### **Дараа үеийн хэмжилт**

*Хорогдуулсан өртгөөр хэмжсэн санхүүгийн хөрөнгө* – Тайлант үе бүрд үр ашигт хүүний аргыг ашиглан тооцсон хорогдуулсан өртгөөр хэмжинэ. Үр ашигт хүүний түвшнээр тооцсон хүүгийн орлогыг тайлант үеийн ашиг, алдагдлаар хүлээн зөвшөөрдөг.

*Бодит үнэ цэнээр хэмжсэн санхүүгийн хөрөнгө* – Тайлант үе бүрийн эцэст бодит үнэ цэнээр нь санхүүгийн хөрөнгийг хэмжинэ. Бодит үнэ цэнийн өөрчлөлтөөс үүссэн олз, гарзыг дараах байдлаар толилуулна. Үүнд:

*Ашиг алдагдлаарх бодит үнэ цэнээр хэмжсэн хөрөнгө* – Тайлант үеийн ашиг, алдагдлын бусад орлого эсвэл бусад зардлаар

*Бусад дэлгэрэнгүй орлогоорх бодит үнэ цэнээр хэмжсэн хөрөнгө* – үнэ цэнийн өөрчлөлтийг "бусад дэлгэрэнгүй орлого"-оор тус тус толилуулна.

Ашиг алдагдлаарх бодит үнэ цэнээр хэмжсэн хөрөнгөөс олсон хүүний орлогыг цэвэр олз, гарзаар тайлагнана.

### **Бодит үнэ цэнийн тооцоолол**

Идэвхтэй зах зээл дээр арилжаалагдсан санхүүгийн хөрөнгө, өр төлбөрийн бодит үнэ цэнийг (олон нийтэд арилжигдсан дериватив болон арилжааны үнэт цаас гэх мэт) тайлант өдрийн арилжаа дуусах үеийн зах зээлийн ханшид үндэслэнэ. Идэвхтэй зах зээл дээр нийтлэгдсэн үнийн саналууд байгаа нь бодит үнэ цэнийн хамгийн сайн нотолгоо бөгөөд хэрэв байгаа бол тэдгээрийг бодит үнэ цэнийг хэмжихэд ашигладаг. "Идэвхтэй зах зээл дээр үнэлэгдсэн" гэсэн хэллэг нь бирж, дилер, брокер, салбарын бүлэг, үнийн үйлчилгээ эсвэл зохицуулах агентлагаас санал болгож буй үнийг бэлэн бөгөөд тогтмол авах боломжтой гэсэн үг юм. Эдгээр үнэ нь зах зээлийн бодит ба тогтмол гүйлгээг илэрхийлдэг бөгөөд энэ нь хүндрэлтэй борлуулалт биш юм. Үнийг үндсэн зах зээлээс эсвэл үндсэн зах зээл байхгүй тохиолдолд хамгийн ашигтай зах зээлээс авч болно [СТОУС13(16)]. Зах зээлийн үнийг гүйлгээний зардалд тохируулах боломжгүй [СТОУС13(25)]. Санхүүгийн хөрөнгө болон санхүүгийн өр төлбөрийн бодит үнэ цэнийг тодорхойлохдоо дараах түвшнийг хэрэглэнэ. Үүнд:

- I түвшин – Идэвхтэй зах зээл дээрх үнэ. Тухайлбал: арилжаа солилцооны зах зээл, дилер, брокер, оролцогчдын хоорондын зах зээл.
- II түвшин – Бодит үнэ цэнд мэдэгдэхүйц нөлөөг шууд ба шууд бусаар үзүүлэх мэдээлэл. Тухайлбал: LIBOR ханшид суурилсан тогтмол хүү авч хөвөгч хүү төлөх хүүний түвшний своп, тодорхой банкны суурь ханшид суурилсан тогтмол хүү авч хөвөгч хүү төлөх хүүний түвшний своп.
- III түвшин – Бодит үнэ цэнд мэдэгдэхүйц нөлөөг үзүүлэх зах зээл дээр ажиглагддаг мэдээллийг ашиглах бусад аргачлалууд

**Санхүүгийн хөрөнгийн үл хүлээн зөвшөөрөлт**

Дараах тохиолдолд санхүүгийн хөрөнгийг данснаас хасна. Үүнд:

- Санхүүгийн хөрөнгөөс орж ирэх мөнгөн урсгалыг хүлээж авах эрхийн хугацаа дууссан, эсвэл
- Уг эрхээ бусдад шилжүүлсэн бөгөөд тухайн хөрөнгийн эрсдэл өгөөж бүрэн шилжсэн эсвэл бүх эрсдэл өгөөжийг шилжүүлээгүй боловч захиран зарцуулах эрхийг нь шилжүүлсэн бол.

Бусад дэлгэрэнгүй орлогоорх бодит үнэ цэнээр хэмжсэн санхүүгийн хөрөнгийг худалдан борлуулсан бол бусад дэлгэрэнгүй орлогоор өмнөх хугацаанд хүлээн зөвшөөрсөн хэрэгжээгүй бодит үнэ цэнийн хуримтлагдсан дүнг тайлант үеийн ашиг алдагдлаар хүлээн зөвшөөрнө.

**Санхүүгийн хөрөнгийн үнэ цэнийн бууралт**

Тайлант хугацаа бүрийн эцэст санхүүгийн хөрөнгийн (эсвэл бүлэг санхүүгийн хөрөнгийн) үнэ цэнэ буурсан байх шинж байгаа эсэхийг үнэлнэ. Анх хүлээн зөвшөөрсний дараа тохиолдсон нэг эсвэл хэд хэдэн үйл явдлаас шалтгаалан үнэ цэнийн бууралт бий болсныг харуулах бодитой нотолгоо байгаа бөгөөд уг үйл явдал нь санхүүгийн хөрөнгийн ( эсвэл бүлэг санхүүгийн хөрөнгийн ) ирээдүйн тооцоолсон мөнгөн урсгалд нөлөөлөхүйц, дүнг тооцоолох боломжтой байгаа үед зөвхөн санхүүгийн хөрөнгийг үнэ цэнэ буурсан гэж үзнэ.

*Хорогдуулсан өртгөөр хэмжсэн санхүүгийн хөрөнгө* – Тайлант үе бүрт хорогдуулсан өртгөөр хэмжигдэх санхүүгийн хөрөнгийн хувьд хөрөнгийн дансны үнэ болон санхүүгийн хөрөнгийн анхны үр ашигт хүүг ашиглан дискаунтчилсан ирээдүйн мөнгөн урсгалын өнөөгийн үнэ цэнийн зөрүүгээр үнэ цэнийн бууралтын алдагдлыг тооцно. Хөрөнгийн дансны үнийг бууруулж, үнэ цэнийн бууралтын алдагдлыг ашиг алдагдлаар хүлээн зөвшөөрнө. Дараагийн хугацаанд үнэ цэнийн бууралтыг хүлээн зөвшөөрсний дараа тохиолдсон үйл явдал (зээлийн чанар сайжирсан г.м)-тэй холбоотойгоор үнэ цэнийн бууралтын алдагдал буурсан бол өмнө нь хүлээн зөвшөөрсөн үнэ цэнийн бууралтын буцаалтыг ашиг алдагдлаар хүлээн зөвшөөрнө.

*Бодит үнэ цэнээр хэмжсэн санхүүгийн хөрөнгө* – Бодит үнэ цэнээр хэмжигдэх санхүүгийн хөрөнгийн үнэ цэнэ буурсны илтгэх бодитой нотолгоо байгаа бол худалдан авсан өртөг болон одоогийн бодит үнэ цэнэ (өмнө нь хүлээн зөвшөөрсөн санхүүгийн хөрөнгийн үнэ цэнийн бууралтыг хассаны дараах) хоорондын зөрүүнээс хуримтлагдсан алдагдлаар өмчийг бууруулж, ашиг алдагдлаар хүлээн зөвшөөрнө. Ашиг, алдагдлаар хүлээн зөвшөөрсөн байсан өмчийн хэрэглүүрт тооцсон үнэ цэнийн бууралтын алдагдлыг дараагийн хугацааны туршид ашиг алдагдал руу буцаахгүй. Бодит үнэ цэнийн хэмжилтийг өөрчлөлт нь бусад дэлгэрэнгүй орлогоор бүртгэгдэх санхүүгийн хөрөнгө гэж ангилсан санхүүгийн хөрөнгийн бодит үнэ цэн өсөлт эсвэл бууралт дараагийн үеүдэд өссөн эсвэл буурсан бол уг өсөлт, бууралтыг өмнөх хугацаанд хүлээн зөвшөөрсөн үнэ цэнийн өсөлт, бууралтын нэгэн адил бусад дэлгэрэнгүй орлогоор бүртгэнэ.

**САНХҮҮГИЙН ӨР ТӨЛБӨР****Ангилал**

МАН нь өр төлбөрийн зорилгоос хамаарч санхүүгийн өр төлбөрөө дараах хоёр ангиллын аль нэгээр нь ангилдаг.

- *Бодит үнэ цэнийн өөрчлөлт нь ашиг, алдагдлаар хэмжигдэх санхүүгийн өр төлбөр*
- *Хорогдуулсан өртгөөр хэмжигдэх санхүүгийн өр төлбөр*

**Хүлээн зөвшөөрөлт ба хэмжилт**

*Бодит үнэ цэнийн өөрчлөлт нь ашиг, алдагдлаар хэмжигдэх санхүүгийн өр төлбөр* - Бодит үнэ цэнийн өөрчлөлт нь ашиг, алдагдлаар хэмжигдэх санхүүгийн өр төлбөрт зөвхөн алдагдалтай санхүүгийн үүсмэл хэрэглүүр багтана. Энэхүү ангилалд санхүүгийн өр төлбөрийг Санхүүгийн байдлын тайланд бодит үнэ цэнээр нь тусгаж, бодит үнэ цэнийн өөрчлөлтийг Орлого үр дүнгийн тайланд тусгана. Ашиг олох зорилгоор бус харин эрсдэлээс хамгаалах зорилгоор үүсмэл хэрэглүүл эзэмшиж гаргадаг. Эдгээр үүсмэл санхүүгийн хэрэглүүрээс бусад тохиолдолд арилжаалагдах зорилготой эсвэл бодит үнэ цэнийг нь ашиг алдагдлаар нь хэмжих зорилготой санхүүгийн өр төлбөр байхгүй болно.

*Бусад санхүүгийн өр төлбөр* - Банкны зээл болон бусад хүү тооцогдох санхүүгийн өр төлбөрийг анх хүлээн зөвшөөрөхдөө тухайн хэрэглүүрийг гаргахтай шууд холбоотой зардлыг бодит үнэ цэнээр

ИНТЕР АУДИТ ХХК

№ 01 огноо 2024.03.12

хассан дүнгээр бүртгэнэ. Ийм төрлийн хүүтэй өр төлбөрийг дараа үеүдэд бүртгэхдээ үр ашигт хүүний түвшинг ашиглан хорогдуулсан өртгөөр хэмждэг. Санхүүгийн өр төлбөрийн хүүний зардалд анхны ажил гүйлгээний зардал, эргэлтээс гаргах өдөр төлөгдөх аливаа нэмүү өртөг болон төлөгдөөгүй өрийн хүү,эсвэл купон багтана. Анх бодит үнэ цэнээр нь хүлээн зөвшөөрсөн дансны өглөг ба бусад богино хугацаат мөнгөөрх өр төлбөрийг дараа үеүдэд үр ашигт хүүний түвшинг хэрэглэн хорогдуулсан өртгөөр хэмжинэ.

#### **Санхүүгийн өр төлбөрийн үл хүлээн зөвшөөрөлт**

МАН санхүүгийн өр төлбөрийг тус өр төлбөртэй холбоотой үүрэг хариуцлага цуцлагдсан, чөлөөлөгдсөн болон хугацаа нь дуусгавар болсон үед үл хүлээн зөвшөөрнө.

#### **САНХҮҮГИЙН БУС ХӨРӨНГӨ, УРЬДЧИЛЖ ТӨЛСӨН ЗАРДАЛ, ТООЦОО**

Гадаад болон дотоодын зах зээлээс түүхий эдматериал худалдан авахаар төлсөн төлбөр, бусад бэлтгэн нийлүүлэгч, гэрээ гүйцэтгэгчид төлсөн урьдчилгааг нэрлэсэн үнээр нь хэмжиж, урьдчилж төлсөн зардал, урьдчилж төлсөн тооцооны хэсэгтнэрийн данс нээж бүртгэдэг.

#### **ҮНДСЭН ХӨРӨНГӨ**

МАН нь үндсэн үйл ажиллагаанд 1-ээс дээш тайлангийн хугацааны туршид ашиглахаар хүлээгдэж буй биет хөрөнгийг үндсэн хөрөнгөд ангилж бүртгэнэ. Үүнд барилга байгууламж, авто машин, тоног төхөөрөмж, тавилга эд хогшил, дуусаагүй барилга байгууламж, бусад хөрөнгүүд орно. Үндсэн хөрөнгийг нягтлан бодох бүртгэлийн ба санхүүгийн тайлагналын олон улсын стандарт, хүлээн зөвшөөрөх нөхцөлийн дагуу, анхны өртгөөр хэмжиж үнэлэн зохих ангиллын дансанд бүртгэнэ. Үндсэн хөрөнгийн өртөг нь худалдан авалтын өртөг, хөрөнгийг ашиглалтын хэвийн нөхцөлд оруулахад шууд хамаарах зардлаас бүрдэнэ. Анхны өртгөөс хуримтлагдсан элэгдэл, үнэ цэнийн бууралтын алдагдлыг хассан цэвэр дүнгээр санхүүгийн тайланд тусгана.

Үндсэн хөрөнгийг дараагийн тайлант үеүдэд дахин үнэлгээний загвараар бүртгэнэ. Дахин үнэлгээний загвараар бүртгэж байгаа үед тухайн хөрөнгийг дахин үнэлсэн шинэчилсэн дүнгээс элэгдлийг тооцож байна.

Үндсэн хөрөнгийн элэгдлийг шулуун шугамын аргаар тооцно. Ашиглалтын хугацааг тухайн хөрөнгийн онцлогоос хамааран тогтоодог.

#### **БИЕТ БУС ХӨРӨНГӨ**

Биет бус хөрөнгө гэж биет шинж чанаргүй, тодорхойлж болохуйц, мөнгөн бус хөрөнгийг хэлнэ. Санхүүгийн байдлын тайланд биет бус хөрөнгийг хуримтлагдсан хорогдол, хуримтлагдсан үнэ цэнийн бууралтыг хассан дансны цэвэр дүнгээр толилуулна.

Тодорхой ашиглалтын хугацаатай биет бус хөрөнгийн хувьд тухайн хөрөнгөөс хүлээгдэж буй эдийн засгийн үр өгөөжид үндэслэн шулуун шугамын аргаар хорогдуулна. Тодорхойгүй ашиглалтын хугацаатай биет бус хөрөнгийг хорогдуулахгүй. Биет бус хөрөнгийн ашиглалтын хугацааг анх авахдаа санхүү эрхэлсэн захирал тогтооно.

Биет бус хөрөнгөнд тооцох ашиглалтын хугацаа, хорогдуулалтын аргыг тайлант үеийн эцэс бүрд дахин хянана.

#### **ӨР ТӨЛБӨР**

Компанийн нийт өр нь богино болон урт хугацаатөр төлбөрүүдээс бүрдэнэ юм. Өр төлбөрүүдийг байгууллага, хувь хүмүүст өгөх өглөг, банкныбогино хугацаат зээл, татвар, нийгмийн даатгалын шимтгэлийн өглөг болон бусад богино хугацаат өглөг,банкны урт хугацаат зээл гэж ангилсан.

Өр төлбөрийг нэрлэсэн үнээр бүртгэж тайлагнана. Тайлант онд компаниас төлөх өр төлбөрүүдэд хөнгөлөлт ба хасагдуулга тооцогдоогүй.

#### **НӨӨЦ**

Төрийн бус байгууллагад хяналтад байгаа нийт нөөцийг хязгаарлалттай болон хязгаарлалтгүй гэж ангилж, санхүүгийн байдлын тайланд харуулна.

Хязгаарлалттай нөөц гэдэг нь хандивлагчийн зүгээс эсвэл хуулийн дагуу ашиглалтын нөхцөлд нь хязгаарлалт тавьсан өмчийг хэлнэ. Хязгаарлалтгүй нөөц гэдэг нь төрийн бус байгууллагын бүрэн мэдэлд байгаа өмчийг хэлнэ.

## ХУРИМТЛАГДСАН ҮР ДҮН

Байгууллага үүсгэн байгуулагдсан цагаас хойших хугацаанд бий болсон хуримтлагдсан ашиг, алдагдлын Байгууллага үүсгэн байгуулагдсан цагаас хойших хугацаанд бий болсон хуримтлагдсан ашиг, алдагдлын нийлбэрээр тодорхойлогдох ба хуримтлагдсан үр дүн дансанд бүртгэх бөгөөд оруулсан хөрөнгийг ашиглан бий болгосон нэмэлт эх үүсвэрийн хэмжээг харуулдаг.

## ҮНДСЭН БА ҮНДСЭН БУС ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГО, ОЛЗ

Байгууллагын орлогод 2005 оны 1 дүгээр сарын 28-ны өдөр баталсан "Улс төрийн намын тухай" хуулийн 16 дугаар зүйлд заасан орлого орох ба аккрузал сууриар бүртгэнэ. Өөрөөр хэлбэл СТОУС 15 Худалдан Авагчидтай Байгуулсан Гэрээний Орлого-ыг мөрддөг. Уг стандартад заасны дагуу Байгууллага нь гэрээгээр нийлүүлэхээр амласан бүтээгдэхүүн, үйлчилгээний хяналт шилжсэн үед орлогыг хүлээн зөвшөөрнө.

Түрээсийн орлого гэдэг нь түрээслүүлэгч зөвшөөрсөн хугацаанд хөрөнгө ашиглах эрхээ тодорхой төлбөртэйгөөр түрээслэгчид шилжүүлэх хэлцэл юм. Байгууллага нь хөрөнгийн өмчлөлтэй холбогдсон бүх эрдэл өгөөжийг түрээслүүлэгчид шилжүүлэхгүй байх тохиолдолд үйл ажиллагааны түрээс байна. Түрээсийн орлогыг СТОУС 16 Түрээс-ийн дагуу бүртгэдэг.

## ҮНДСЭН БА ҮНДСЭН БУС ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДАЛ, ГАРЗ

Тайлант хугацаанд мөнгөний гадагш урсгал хэлбэрээр хөрөнгийг бүрдүүлж, өр төлбөр ихэсгэдэг эдийн засгийн өгөөжийн бууралт гарах үед зардлыг хүлээн зөвшөөрдөг. Зардлыг тухайн гарсан үед нь ашиг, алдагдал болон бусад орлогын дэлгэрэнгүй тайланд хүлээн зөвшөөрнө.

## ХОЛБООТОЙ ТАЛУУД

Холбоотой тал гэдэг нь нэгтгэсэн санхүүгийн тайлан бэлтгэж байгаа байгууллагатай холбоотой хүн эсвэл байгууллага юм. Тухайн хүн эсвэл тэр хүний гэр бүлийн ойрын гишүүн нь тайлагнагч байгууллагатай холбоотой бөгөөд уг хүн нь:

- Тайлагнагч байгууллагад хяналттай эсвэл хамтарсан хяналттай,
- Тайлагнагч байгууллагад үлэмж хэмжээний нөлөөтэй,
- Тайлагнагч байгууллага, тайлагнагч байгууллагын дээд байгууллагын гол удирдлагын багийн гишүүн байх.

Байгууллага болон түүнтэй холбоотой этгээдүүдийн хооронд ажил үйлчилгээ эсвэл үүрэг хариуцлага шилжүүлэхдээ төлбөр нэхэмжилсэн эсэхээс үл хамааран тэдгээрийн хооронд хийгдсэн ажил гүйлгээг холбоотой талуудтай хийсэн ажил гүйлгээ гэнэ.

Хэрэв доорх нөхцөлийн аль нэг нь хангагдаж байвал тухайн байгууллагыг холбоотой тал гэж үзнэ. Үүнд:

1. Байгууллага ба тайлагнагч байгууллага нь нэг ижил байгууллагын (энэ нь толгой, охин болон дэд охин компани нь бусадтай холбоотой багтдаг) гишүүд байх,
2. Нэг байгууллага нөгөө байгууллагын хараат компани эсвэл хамтарсан үйлдвэр/хөрөнгө оруулалтын нэг тал нь байх (эсвэл нөгөө байгууллагын гишүүнчлэлтэй группийн нэг гишүүний хараат компани эсвэл хамтарсан үйлдвэр/хөрөнгө оруулалтын нэг тал нь байх),
3. Хоёр байгууллага нь гуравдагч байгууллагын хамтарсан үйлдвэр/хөрөнгө оруулалтын талууд байх,
4. Нэг байгууллага нь гуравдагч байгууллагын хамтарсан үйлдвэр/хамтарсан хөрөнгө оруулалтын нэг хэсэг болох ба нөгөө байгууллага нь гуравдагч байгууллагын хараат компани байх,
5. Байгууллага нь тайлагнагч байгууллага эсвэл тайлагнагч байгууллагатай холбоотой байгууллагын аль алины ажилчдын тэтгэмжийн "ажил эрхлэлтийн дараах тогтоосон тэтгэмжийн төлөвлөгөө"-нд хамаарах. Хэрэв тайлагнагч байгууллага нь өөрөө энэ төлөвлөгөөний нэг хэсэг бол спонсор ажил олгогчид нь тайлагнагч байгууллагатай мөн холбоотой талууд болох,
6. Тухайн байгууллага нь дээр дурдсан холбоотой талаар тодорхойлогдсон хувь хүний шууд эсвэл хамтарсан хяналтын дор байх.

ҮЗҮҮЛЭЛТ	2022.12.31	2023.12.31
<b>4. МӨНГӨ, ТҮҮНТЭЙ АДИЛТГАХ ХӨРӨНГӨ</b>		
Касс	12,550,155.08	6,337,686.93
Банкин дахь мөнгө	345,347,597.87	1,032,577,778.27
Мөнгөтэй адилтгах хөрөнгө	-	-
<b>ДҮН</b>	<b>357,897,752.95</b>	<b>1,038,915,465.20</b>

Тайлбар: МАН нь 21 аймаг болон нийслэл дэх намын салбар хороодыг касстай байхыг зөвшөөрдөг байна. Мөн төв болон салбарууд нь арилжааны банкуудад төгрөгийн харилцах данстай бөгөөд мөнгөтэй адилтгах өөр хөрөнгө байхгүй байна.

ҮЗҮҮЛЭЛТ	ДАНСНЫ АВЛАГА	НАЙДВАРГҮЙ АВЛАГЫН ХАСАГДУУЛГА	ДАНСНЫ АВЛАГА (ЦЭВЭР ДҮНГЭЭР)
<b>5. ДАНСНЫ АВЛАГА</b>			
Эхний үлдэгдэл	538,155,405.87	-	538,155,405.87
Нэмэгдсэн	1,139,716,125.60	-	1,139,716,125.60
Хасагдсан:	(1,217,351,576.06)	-	(1,217,351,576.06)
Төлөгдсөн	(1,217,351,576.06)	-	(1,217,351,576.06)
Найдваргүй болсон	-	-	-
<b>ЭЦСИЙН ҮЛДЭГДЭЛ</b>	<b>460,519,955.41</b>	<b>-</b>	<b>460,519,955.41</b>

Тайлбар: Дансны авлага нь Нийслэл болон орон нутгууд дахь МАН-ын байрны түрээсийн авлага, ажилчдаас авах авлага, бага хурлын гишүүний татварын авлага болон бусад авлагуудаас бүрдсэн байна.

ҮЗҮҮЛЭЛТ	ТҮҮХИЙ ЭД МАТЕРИАЛ	БЭЛЭН БҮТЭЭГДЭХҮҮН	БАРАА	ХАНГАМ- ЖИЙН МАТЕРИАЛ	НИЙТ
<b>6. БАРАА МАТЕРИАЛ</b>					
Эхний үлдэгдэл	4,582,000.00	-	81,353,217.25	240,298.00	86,175,515.25
Эцсийн үлдэгдэл	-	-	41,852,245.00	1,600,000.00	43,452,245.00
Хасагдсан	(52,000.00)	-	(52,595,928.95)	(26,000.00)	(52,673,928.95)
Эцсийн үлдэгдэл	<b>4,530,000.00</b>	<b>-</b>	<b>70,609,533.30</b>	<b>1,814,298.00</b>	<b>76,953,831.30</b>
Үнийн бууралтын гарз	-	-	-	-	-
Дансны цэвэр дүн	-	-	-	-	-
Эхний үлдэгдэл	4,582,000.00	-	81,353,217.25	240,298.00	4,582,000.00
<b>ЭЦСИЙН ҮЛДЭГДЭЛ</b>	<b>4,582,000.00</b>	<b>28,786,782</b>	<b>70,609,533.30</b>	<b>1,814,298.00</b>	<b>4,582,000.00</b>

ҮЗҮҮЛЭЛТ	2022.12.31	2023.12.31
<b>7. БУСАД ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГӨ</b>		
Санхүүгийн бус хөрөнгө – Баян-Өлгий	5,020,386.00	5,020,386.00
Бусад эргэлтийн хөрөнгө – Булган	-	13,358,577.00
Бусад эргэлтийн хөрөнгө - Багахангай	2,066,000.00	2,066,000.00
<b>ДҮН</b>	<b>7,086,386.00</b>	<b>20,444,963.00</b>

8. ҮНДСЭН ХӨРӨНГӨ	БАРИЛГА	МАШИН, ТОНОГ ТӨХӨӨРӨМЖ	ТЭЭВРИЙН ХЭРЭГСЭЛ	ТАВИЛГА, ЭД ХОГШИЛ	КОМПЬЮТЕР БУСАД	НИЙТ
Эхний үлдэгдэл	27,032,177,488.89	994,571,493.76	1,298,008,376.00	1,451,416,783.64	826,715,670.54	31,602,889,812.83
Нэмэгдсэн	-	80,338,486.00	-	249,981,114.00	135,068,605.00	90,957,600.00
Дахин үнэлгээний нэмэгдэл	-	-	-	-	-	-
Хасагдсан	-	(72,623,500.00)	-	(450,786,457.00)	(171,093,846.00)	(314,163,257.00)
<b>Эцсийн үлдэгдэл</b>	<b>27,032,177,488.89</b>	<b>1,002,286,479.76</b>	<b>1,298,008,376</b>	<b>1,254,006,440.64</b>	<b>790,690,429.54</b>	<b>31,377,169,214.83</b>

Тайлбар: Тайлант онд МАН нь өөрийн дансанд бүртгэлтэй үндсэн хөрөнгүүдэд элэгдэл тооцоогүй байна. Өөрөөр хэлбэл түүхэн өртгөөрөө хэмжигдсэн байна.

ҮЗҮҮЛЭЛТ

9. БИЕТ БУС ХӨРӨНГӨ	2022.12.31	2023.12.31
Биет бус хөрөнгө - салбарууд дахь	522,540.00	522,540.00
Программ хангамж	34,380,000.00	35,220,000.00
Бусад	40,100,000.00	40,000,000.00
<b>ДҮН</b>	<b>75,002,540.00</b>	<b>75,742,540.00</b>

Тайлбар: Тайлант онд МАН нь биет бус хөрөнгөдөө мөн хорогдуулалт тооцоогүй.

ҮЗҮҮЛЭЛТ

10. ДАНСНЫ ӨГЛӨГ	2022.12.31	2023.12.31
Дансны өглөг - Төв	22,700,000.00	22,700,000.00
Дансны өглөг - Салбарууд	225,281,888.74	225,489,488.74
<b>ДҮН</b>	<b>247,981,888.74</b>	<b>248,189,488.74</b>

Тайлбар: Тайлант оны эхэнд Улаанбаатар хотын 1 дүүрэг, орон нутгийн 8 аймгийн салбарууд дансны өртэй байсан. Тайлант оны эцэст мөн эдгээр салбаруудын дансны өр төлбөр байсаар байна.

ҮЗҮҮЛЭЛТ

11. ЦАЛИНГИЙН ӨГЛӨГ	2022.12.31	2023.12.31
Цалингийн өглөг - Төв	-	-
Цалингийн өглөг - Салбарууд	58,577,537.47	60,980,011.11
<b>ДҮН</b>	<b>58,577,537.47</b>	<b>60,980,011.11</b>

Тайлбар: Тайлант онд МАН-ын Төв байгууллагад ажиллаж буй ажилтнуудтай холбоотойгоор нийт 2,127,339.5 мянган төгрөгийн цалингийн зардал гарсан байна. Бусад буюу Улаанбаатар хотын дүүргүүд, орон нутаг дахь салбаруудад ажиллаж буй ажилтнуудтай холбоотойгоор 1,781,919.4 мянган төгрөгийн цалингийн зардал гарсан байна.

ҮЗҮҮЛЭЛТ

12. ХХОАТ-ЫН ӨГЛӨГ	2022.12.31	2023.12.31
ХХОАТ-ын өглөг - Төв	186,363,857.40	50,453,803.11
ХХОАТ-ын өглөг - Салбарууд	103,264,263.50	141,788,962.74
<b>ДҮН</b>	<b>289,628,120.90</b>	<b>192,242,765.85</b>

ҮЗҮҮЛЭЛТ

13. НДШ-ИЙН ӨГЛӨГ	2022.12.31	2023.12.31
НДШ-ийн өглөг - Төв	69,902,942.85	-
НДШ-ийн өглөг - Салбарууд	100,548,597.70	126,328,634.84
<b>ДҮН</b>	<b>170,451,540.55</b>	<b>126,328,634.84</b>

## ҮЗҮҮЛЭЛТ

	2022.12.31	2023.12.31
<b>14. БУСАД ӨГЛӨГ</b>		
Холбоотой талуудад өгөх өглөг	606,000.00	1,046,320.00
Хувь хүмүүст өгөх өглөг	1,512,502,990.00	1,529,064,111.00
Бусад өглөг	56,587,890.00	56,587,890.00
<b>дүн</b>	<b>1,569,696,880.00</b>	<b>1,586,698,321.00</b>

Тайлбар: Тайлант онд МАН-ын бусад өглөгийн дүнд материаллаг өөрчлөлт ороогүй байна. Өөрөөр хэлбэл бусад өглөгийн дансны "хувь хүмүүст өгөх өглөг" данс нь 1,529,064.1 мянган төгрөг байгаа бөгөөд дийлэнх өглөг нь өмнөх онуудад үүссэн байна. Үүнээс, Төв байгууллагын хувь хүмүүст өгөх өглөг 1,410,610.6 мянган төгрөг байна.

## ҮЗҮҮЛЭЛТ

	2022.12.31	2023.12.31
<b>15. ЦЭВЭР ХӨРӨНГӨ</b>		
НӨӨЦ: Хязгаарлалттай	18,608,683,245.45	18,608,683,245.45
Хязгаарлалтгүй	4,364,511,202.43	4,364,511,202.43
Дахин үнэлгээний нэмэгдэл	4,755,617,700.00	4,755,617,700.00
Хуримтлагдсан үр дүн	2,532,942,866.68	3,037,378,169.64
<b>дүн</b>	<b>30,261,755,014.56</b>	<b>30,766,190,317.52</b>

Тайлбар: Тайлант онд байгууллагын хязгаарлалттай болох хязгаарлалтгүй нөөцөд өөрчлөлт оруулах ямар нэг шийдвэрийг гаргаагүй байна. Сан хөмрөгийн газраас 2011 онд МАН-ын үндсэн хөрөнгийг дахин үнэлсэн ба үүссэн дахин үнэлгээний нэмэгдлийг хүлээн зөвшөөрч бүртгэсэн байна. Тайлант онд дахин үнэлсэн хөрөнгүүдэд хөдөлгөөн үүсээгүй тул "дахин үнэлгээний нэмэгдэл" дансны дүнд өөрчлөлт ороогүй байна. Тайлант онд мөн 492,317.7 мянган төгрөгийн ашигтай ажилласнаар Хуримтлагдсан үр дүн данс 3,037,378.2 мянган төгрөг болж өсжээ.

## ҮЗҮҮЛЭЛТ

	2022.12.31	2023.12.31
<b>16. ҮНДСЭН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГО</b>		
Гишүүдийн татвар	1,768,249,551.58	1,892,109,849.00
Хөтөлбөр, төслийн орлого	2,199,990,000.00	2,033,095,481.00
Бэлэг, хандив, тусламжийн орлого	2,941,494,099.00	333,390,000.00
Түрээсийн орлого	1,000,980,500.42	2,608,437,394.00
Бусад орлого	-	1,795,665,000.00
<b>НИЙТ</b>	<b>7,910,714,151.00</b>	<b>8,662,697,724.00</b>

Тайлбар: МАН-ын төв болон салбарууд өөрийн барилга, байгууламжийн зарим оффисын өрөө, заал, талбай, автомашины зогсоолыг бусдад түрээслүүлдэг. Мөн тодорхой хэмжээний санхүүжилтийг Монгол Улсын Төсвөөс авдаг байна.

## ҮЗҮҮЛЭЛТ

	2022.12.31	2023.12.31
<b>17. ЕРӨНХИЙ БА УДИРДЛАГЫН ЗАРДАЛ</b>		
Цалин хөлс шагнал	4,013,850,008.20	4,142,223,685.02
Нийгмийн даатгалын шимтгэл	495,234,423.90	511,051,318.89
Засвар үйлчилгээний зардал	182,674,097.79	171,422,938.70
Ашиглалтын зардал	526,830,338.23	492,636,607.66
Түрээсийн зардал	47,490,000.00	1,620,000.00
Албан томилолтын зардал	16,575,520.00	90,862,630.00
Тээврийн зардал	5,331,300.00	3,844,480.00
Түүхий эд материалын зардал	292,475,645.44	205,845,264.95
Элэгдлийн зардал	-	-
Зар сурталчилгааны зардал	7,587,184.00	58,848,000.00
Шуудан, холбооны зардал	65,143,262.42	78,260,045.83
Шатахууны зардал	106,174,160.00	170,187,926.00
Найдваргүй авлагын зардал	-	-
Шагнал, урамшууллын зардал	261,829,833.00	406,651,000.00
Зээлийн хүүгийн зардал	-	-
Бусад зардал	1,716,685,614.25	1,485,975,838.79
<b>ДҮН</b>	<b>7,737,881,387.23</b>	<b>7,819,429,735.84</b>

Тайлбар: Бусад зардалд толилуулсан дүнд судалгаа, суртал ухуулга, хурал, арга хэмжээ, зочин төлөөлөгч, бэлэг дурсгал, дэмжлэгийн зардлууд ордог. Үйл ажиллагааны зардлын 75 хувийг цалингийн болон дээрх бусад зардлууд эзэлж байна. Өмнөх тайлант үетэй харьцуулахад мэдэгдэхүйц өөрчлөлт орсон зардал байхгүй.

## 18. ҮҮРЭГ ХАРИУЦЛАГА БА БОЛЗОШГҮЙ ЗҮЙЛС

Тайлант хугацаанд өнгөрсөн үйл явдлын улмаас хуулийн үүрэг хариуцлага үүсгэж болохуйц эрсдэлтэй үйл явдал үүсээгүй байна.

## 19. БАЛАНСЫН ДАРААХ ҮЙЛ ЯВДАЛ

Энэхүү тайланг 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр тасалбар болгон 2024 оны 03 дугаар сарын 13-ны өдөр бэлтгэсэн. Тасалбар болгосноос хойш тайлант нөлөөлөх /залруулагдах/ үйл явдал гараагүй.

## 20. ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГА

Компанид Тодруулгын “Үүрэг хариуцлага ба болзошгүй зүйлс” хэсэгт тусгагдсан эрсдэлүүдээс гадна санхүүгийн хэрэгслүүдийг хэрэглэх явцад дараах нийтлэг эрсдэлүүд тулгарч болно.

- Хууль, эрх зүйн орчны хувьд нэмэлт өөрчлөлт гарах, шинэ хууль тогтоомж, дүрэм журам батлагдсанаар шинэ болон шинэчлэн найруулсан хууль, тогтоомж, дүрэм журмын мөрдөлттэй холбоотой үл нийцлийн эрсдэл.
- МАН-ын гишүүдийн хувийн болон намын үйл ажиллагаатай холбоотой хууль тогтоомж зөрчсөнөөс үүсэх МАН-ын нэр хүнд, үйл ажиллагаанд сөргөөр нөлөөлж болохуйц эрсдэл.
- МАН-ын нэр хүнд, үйл ажиллагаанд сөргөөр нөлөөлж болохуйц гүтгэлэг болон худал мэдээлэл тараан түгээх эрсдэл.
- Тайлант оны нэгтгэсэн санхүүгийн тайланд шинжилгээ хийж үзэхэд эргэлтийн хөрөнгийн дүн эргэлтийн бус хөрөнгийн дүнтэй харьцуулахад мэдэгдэхүйц бага байгаа нь төлбөрийн чадварын болон ердийн үйл ажиллагааг тасралтгүй явуулахад сөрөг нөлөө үзүүлэхүйц эрсдэл.

### Зах зээлийн эрсдэл (Гадаад валютын эрсдэл)

Гадаад валютын эрсдэл гэдэг нь төгрөгөөс бусад валютаар илэрхийлэгдсэн ажил гүйлгээний ханшийн өөрчлөлтөөс үүсэх санхүүгийн хүндрэл юм. Гадаад валютын ханшийн эрсдэлээс сэргийлэхийн тулд зах зээл дээрх хамгийн боломжит ханшийг баримтлах бодлого баримталдаг.

### Зах зээлийн эрсдэл (Хүүний түвшний эрсдэл)

Хүүний түвшний эрсдэл гэдэг нь зах зээл дээрх хүүний түвшний өөрчлөлтийн улмаас санхүүгийн хэрэглүүрийн бодит үнэ цэнэ эсвэл ирээдүйд гарах мөнгөн гүйлгээний хэлбэлзэх эрсдэл юм.

### Зах зээлийн эрсдэл (Бодит үнэ цэнийн эрсдэл)

Бодит үнэ цэнийн эрсдэл гэдэг нь зах зээл дээр ханшийн өөрчлөлтийн улмаас эзэмшиж буй хөрөнгийн үнэ цэнэ буурах эрсдэл юм. Бодит үнэ цэнийн эрсдэлээс сэргийлэхийн тулд зах зээл дээрх хамгийн боломжит ханшийг баримтлах бодлого баримталдаг.

## 21. БУСАД

МАН-ын нэгтгэсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан, дүгнэлтийг 2023 оны 12 сарын 31-ний өдрөөр тасалбар болгон Монгол хэл дээр 2 хувь бэлтгэсэн бөгөөд хуулбарт утгын зөрүү гарвал эх хувийг баримтлах болно.

## “ИНТЕР АУДИТ” ХХК

Аудитын компанийн хаяг:

Монгол улс, Улаанбаатар хот,  
Чингэлтэй дүүрэг, 5-р хороо, 6-р  
хороолол, Самбуугийн гудамж, Эм  
Эн тауэр 802 тоот

Холбогдох:

Утас: 99004839

Веб хуудас: [www.interaudit.mn](http://www.interaudit.mn)

Фэйсбүүк хуудас: Интер Аудит ХХК / Inter Audit LLC

Мэйл хаяг: [info@interaudit.mn](mailto:info@interaudit.mn)